



ДУНДГОВЬ АЙМГИЙН
САЙНЦАГААН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 09 сарын 07 өдөр

Дугаар 4/130

Мандалговь

Шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх
Дархлаажуулалтын ажлыг зохион
байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3-ын "а", Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4, 9.5, 9.6, 9.7 дахь заалтууд, Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын 2021 оны 09 дүгээр сарын 03-ны өдрийн А/214 тоот тушаал, аймгийн Засаг даргын 2021 оны 09 сарын 07-ны өдрийн А/336 тоот захирамжийг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх яаралтай дархлаажуулалтыг 2021 оны 09 дүгээр сарын 07-оос эхлэн 10 хоногийн хугацаанд багтаан зохион байгуулсугай.

2. Шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын товыг малчид, мал бүхий иргэдэд хүргэж ажиллахыг багийн Засаг дарга нарт, өвчинд мэдрэмтгий мал сүргийг дархлаажуулалтанд бүрэн хамруулж, чанартай гүйцэтгэхийг Мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн эмч нарт үүрэг болгосугай.

3. Шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын ажлыг мэргэжлийн удирдлага, арга зүйгээр ханган, шуурхай үр дүнтэй зохион байгуулж хяналт тавьж ажиллахыг Мал эмнэлгийн тасгийн дарга, улсын байцаагч (Е.Отгонцэцэг), тархвар зүйч эмч (Д.Эрдэнэцэцэг) нарт даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



С.БАТ-ОРГИЛ